



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn  
Аудитор: Б.Азжаргал  
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	2
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа .....	12
4.4 Зөвлөмж .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл аудитлагдаагүй	Эцсийн үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,652,886.11	65,652,886.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	198,646.05	198,646.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	198,646.05	198,646.05
31213	Арилжааны банк дахь харилцах	198,646.05	198,646.05
35	БАРАА МАТЕРИАЛ	65,454,240.06	65,454,240.06
351	Түүхий эд материал	63,166,801.06	63,166,801.06
35110	Тусгай зориулалттай материал	63,166,801.06	63,166,801.06
354	Хангамжийн материал	2,287,439.00	2,287,439.00
35440	Түлш, шатах тослох материал	360,000.00	360,000.00
35460	Хүнсний материал	1,927,439.00	1,927,439.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	451,392,130.74	451,392,130.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	451,392,130.74	451,392,130.74
392	Биет хөрөнгө	440,874,130.74	440,874,130.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	406,751,783.88	406,751,783.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(105,715,762.09)	(105,715,762.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,696,690.00	48,696,690.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,598,703.70)	(36,598,703.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,716,422.60	125,716,422.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,804,348.14)	(41,804,348.14)
39209	Зам, гүүрийн байгууламж	58,394,395.80	58,394,395.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(14,566,347.61)	(14,566,347.61)
393	Биет бус хөрөнгө	10,518,000.00	10,518,000.00
39301	Програм хангамж	528,469.00	528,469.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(528,469.00)	(528,469.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,518,000.00	10,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	517,045,016.85	517,045,016.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	517,045,016.85	517,045,016.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	194,607,200.18	194,607,200.18
	Дахин үнэлгээний нөөц	316,465,539.62	316,465,539.62
512	Хуримтлагдсан үр дүн	5,972,277.05	5,972,277.05
51210	Өмнөх үеийн үр дүн	52,433,864.09	52,433,864.09
51220	Тайлант үеийн үр дүн	(46,461,587.04)	(46,461,587.04)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	517,045,016.85	517,045,016.85

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл

**Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	429,512,233.00	429,512,233.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,906,833.00	31,906,833.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,906,833.00	31,906,833.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00	285,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	285,000.00	285,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,054,300.00	45,054,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,054,300.00	45,054,300.00
1330	Төсвийн захирагчдаас	352,266,100.00	352,266,100.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	352,266,100.00	352,266,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,721,877.28	474,721,877.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,721,877.28	474,721,877.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,188,496.11	291,188,496.11
210101	Үндсэн цалин	188,963,627.40	188,963,627.40
210102	Нэмэгдэл	81,129,771.71	81,129,771.71
210104	Урамшуулал	21,095,097.00	21,095,097.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,524,500.00	39,524,500.00
210201	Тэтгэврийн даатгал	27,722,100.00	27,722,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,950,600.00	2,950,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,360,500.00	2,360,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,100.00	590,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,901,200.00	5,901,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,912,197.43	43,912,197.43
210301	Гэрэл, цахилгаан	3,784,275.43	3,784,275.43
210302	Түлш, халаалт	36,202,342.00	36,202,342.00
210303	Цэвэр, бохир ус	3,925,580.00	3,925,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,373,150.00	4,373,150.00
210401	Бичиг хэрэг	591,350.00	591,350.00
210402	Тээвэр, шатахуун	775,000.00	775,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,300.00	70,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,378,400.00	1,378,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,558,100.00	1,558,100.00
2105	Нормативт зардал	12,320,881.00	12,320,881.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,900.00	49,900.00
210502	Хоол, хүнс	11,791,881.00	11,791,881.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	479,100.00	479,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,756,100.00	12,756,100.00
210604	Урсгал засвар	12,756,100.00	12,756,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,120,036.28	65,120,036.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	273,300.00	273,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,562,100.00	1,562,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,284,636.28	63,284,636.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,026,516.46	5,026,516.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,026,516.46	5,026,516.46

**Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(45,209,644.28)	(45,209,644.28)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,251,942.76	1,251,942.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,251,942.76	1,251,942.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,251,942.76)	(1,251,942.76)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(46,461,587.04)	(46,461,587.04)

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

АУДИТЛАГДСАН					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,607,200.18	316,465,539.62	61,515,219.89	572,587,959.69
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	194,607,200.18	316,465,539.62	61,515,219.89	572,587,959.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(9,081,355.80)	(9,081,355.80)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,607,200.18	316,465,539.62	52,433,864.09	563,506,603.89
D08	Тайлант үеийн үр дүн			(46,461,587.04)	(46,461,587.04)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,607,200.18	316,465,539.62	5,972,277.05	517,045,016.85

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>400,127,957.00</u>	<u>400,127,957.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00	285,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	285,000.00	285,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,054,300.00	45,054,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,054,300.00	45,054,300.00
1330	Төсвийн захирагчдаас	352,266,100.00	352,266,100.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	352,266,100.00	352,266,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,522,557.00	2,522,557.00

**Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,522,557.00	2,522,557.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	400,627,957.00	400,627,957.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,627,957.00	400,627,957.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,188,496.11	291,188,496.11
210101	Үндсэн цалин	188,963,627.40	188,963,627.40
210102	Нэмэгдэл	81,129,771.71	81,129,771.71
210104	Урамшуулал	21,095,097.00	21,095,097.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,524,500.00	39,524,500.00
210201	Тэтгэврийн даатгал	27,722,100.00	27,722,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,950,600.00	2,950,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,360,500.00	2,360,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,100.00	590,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,901,200.00	5,901,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,912,197.43	43,912,197.43
210301	Гэрэл, цахилгаан	3,784,275.43	3,784,275.43
210302	Түлш, халаалт	36,202,342.00	36,202,342.00
210303	Цэвэр, бохир ус	3,925,580.00	3,925,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,665,000.00	2,665,000.00
210401	Бичиг хэрэг	143,800.00	143,800.00
210402	Тээвэр, шатахуун	935,000.00	935,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,300.00	70,300.00
210404	Ном, хэвлэл	32,300.00	32,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,600.00	249,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,234,000.00	1,234,000.00
2105	Нормативт зардал	12,347,190.00	12,347,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,900.00	49,900.00
210502	Хоол, хүнс	11,818,190.00	11,818,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	479,100.00	479,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,142,100.00
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,142,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,799,400.00	1,799,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	273,300.00	273,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,526,100.00	1,526,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,022,557.00	3,022,557.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,522,557.00	2,522,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,026,516.46	5,026,516.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,026,516.46	5,026,516.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(500,000.00)</u>	<u>(500,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(500,000.00)</u>	<u>(500,000.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	698,646.05	698,646.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	198,646.05	198,646.05

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,320,400.00	395,351,440.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,320,400.00	395,351,440.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,320,400.00	392,328,883.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,058,300.00	291,188,496.11
210101	Үндсэн цалин	161,857,800.00	188,963,627.40
210102	Нэмэгдэл	107,366,400.00	81,129,771.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,535,300.00	-
210104	Урамшуулал	23,298,800.00	21,095,097.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,524,500.00	39,524,500.00
210201	Тэтгэврийн даатгал	27,722,100.00	27,722,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,950,600.00	2,950,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,360,500.00	2,360,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,100.00	590,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,901,200.00	5,901,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,912,200.00	43,912,197.43
210301	Гэрэл, цахилгаан	3,011,500.00	3,784,275.43
210302	Түлш, халаалт	35,900,700.00	36,202,342.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	3,925,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,415,900.00	2,415,000.00
210401	Бичиг хэрэг	86,800.00	108,800.00
210402	Тээвэр, шатахуун	935,900.00	935,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,300.00	70,300.00
210404	Ном, хэвлэл	54,300.00	32,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,900.00	160,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,107,700.00	1,107,700.00
2105	Нормативт зардал	13,377,600.00	12,347,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,900.00	49,900.00
210502	Хоол, хүнс	12,848,600.00	11,818,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	479,100.00	479,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,142,100.00
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,142,100.00
2107	Томилолт, зочны зардал	88,700.00	-
210702	Дотоод албан томилолт	88,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,801,100.00	1,799,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	275,000.00	273,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,526,100.00	1,526,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,022,557.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,022,557.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	2,522,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	397,320,400.00	399,842,957.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	352,266,100.00	352,266,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,266,100.00	352,266,100.00

**Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,054,300.00	45,054,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	45,054,300.00	45,054,300.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	2,522,557.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	2,522,557.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		698,646.05
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		198,646.05

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	250,000.00
210401	Бичиг хэрэг	35,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	126,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг нь Хүүхдийн сурах үйлийг дэмжиж хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өрөгжүүлэн тэдний хөгжил төлөвшилд ахиц гаргах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий БШУЯамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 395,351.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,953.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг өөрчлөөгүй бөгөөд 70 хувиар буюу 2,767.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Жаргалант сумын 3-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,461.6 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	698.6	198.6	( 500.0)
Бараа материал	64,096.4	65,454.2	1,357.0
Үндсэн хөрөнгө	640,741.7	650,605.8	9,864.1
Авлага			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>563,506.6</b>	<b>517,045.1</b>	<b>(46,461.5)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	563,506.6	517,045.1	(46,461.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>563,506.6</b>	<b>517,045.1</b>	<b>(46,461.5)</b>

Бараа материалын данс 65,454.2 мянган төгрөг болж 1,357.0 мянган төгрөгөөр өссөн нь шатах тослох материал, хүнсний материалын үлдэгдэл, тусгай зориулалтын материалын нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 650,605.8 мянган төгрөг болж 9,864.1 мянган төгрөгөөр өссөн нь БСГ-аас 1,853.5 мянган төгрөгийн, БШУЯамны хөрөнгө оруулалтаар 15,363.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүд бэлтгэгдэж ирсэн ба 7,353.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 517,045.1 төгрөг болж 46,461.5 төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 34,980.1 мянган төгрөгөөр буюу 7,5 хувиар буурч, нийт зардал өмнөх оноос 1,148.2 мянган төгрөгөөр буюу 0,24 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын 3-р цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 593,056.4 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэнээс 397,320.4 мянган төгрөгөөр батлагдан ирсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 352,266.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн орлогоос 45,054.3 мянган төгрөг, БСГ-аас ариутгалын зардалд 250.0 төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 35.0 төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд нийт 400,627.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 400,627.5 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 291,188.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 39,524.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43,912.2 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 2,665.0 мянган төгрөг, норматив зардал 12,347.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 1,142.1 мянган төгрөг, томиллолт

зочны зардал 0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 0 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 1,799.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 500.0 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болох 5,026.5 мянган төгрөгийг төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас 250.0 төгрөгийн санхүүжилтын ариутгал халдваргүйтгэлийн зардал болгон өгсөн бөгөөд үүнийг 2 удаагийн ариутгал халдваргүйтгэл хийгдсэн ба ариутал халдваргүйтгэлийн бодис худалдан авсан байна.

Мөн төсөвт байгууллагын өөрийн өөрийн орлого болох 35.0 мянган төгрөг тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтын дансанд орсоныг Засгийн газрын 43-р тогтоолыг үндэслэн төрийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг нь 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 130 мэдээллийг байршуулж 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин хугацаа хоцролттой байна.

Зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 34.3.2-д "тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй", Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д "заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 165,167.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 112,377.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 52,790.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	2	52,790.1	2	52,790.1			
Албан шаардлага	2	112,377.3	2	112,377.3			
Нийт дүн	4	165,167.4	4	165,167.4			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,867.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,522.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 478.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 866.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 2,522.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

#### **4.2 Төлбөрийн акт**

##### **1.1. Илрүүлэлт:**

Сахилагын шийтгэлтэй ажилтанд 478.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" хавсралттай нийцэхгүй байна.

#### **4.3 Албан шаардлага Байхгүй.**

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 866.4 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

#### **2.3. Илрүүлэлт:**

149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15 мэдээ мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д "заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд хугацаа хоцроолгүй мэдээлж байх.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын цэцэрлэг	4	3,867.0	1	2,522.6	1	478.0	0	0	2	866.4